



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/322.

Мандалговь

Г Тусгай зөвшөөрлийн эрх 7
олгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын татварын хэлтэст бүртгэлтэй "ОНӨНҮҮГ"-ын харьяа Сүм хөх бүрд аялал жуулчлалын баазад архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 7 дугаар сарын 9-ны өдрөөс 2019 оны 7 дугаар сарын 9-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн эрх олгогдсон "ОНӨНҮҮГ"-ын харьяа Сүм хөх бүрд аялал жуулчлалын баазын ажиллах цагийн хуваарийн 09.00 -23.00 цаг хүртэл хугацаагаар баталсугай.

Гурав. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон шийдвэрийг холбогдох газарт хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Ц.Сугаржав/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

495010065